## АГУУЛГА

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар…………………….......................... 2

1.2. Байгууллагын хүний нөөцийн талаар……………………………………......... 2

1.3. Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд ................. 2

1.4. Хяналт шалгалтын чиглэлээр ........................................................................ 3

1.5. Тоон гарын үсэг олголтын талаар ................................................................ 3

1.6. Иргэний бүртгэлийн чиглэлээр ..................................................................... 4

1.7. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр ............................................. 4-5

1.8. Хуулийн этгээдий бүртгэлийн чиглэлээр ...................................................5-6

1.9. Санхүүгийн чиглэлээр ....................................................................................8-9

1.10. Архивын үйл ажиллагааны чиглэлээр ..................................................... 9-10

1.11. Мэдээлэл технологийн чиглэлээр ............................................................. 11

**ХОЁР. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР** ........................................................................... 11-12

**ГУРАВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР** .................. .. 13-14

## НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. *Удирдлага зохион байгуулалтын талаар:*

Булган аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулан бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах өнөөдрийн байдлаар 28 албан хаагчидтайгаар иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр Булган аймгийн 1 тосгон 16 сумын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Тус хэлтэст 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт ирсэн албан бичиг 824, үүнээс хариутай 454 албан бичгийн 449 албан бичгийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Хугацаа болоогүй 5 албан бичиг байгаа бөгөөд явуулсан албан бичиг 901, өргөдөл гомдол нийт 93 ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 85, хуулийн хугацаа болоогүй 8 өргөдлийг шалгаж байгаа болно.

Хэлтсийн үнэт цаас, бараа материал зэргийг найдвартай тоо бүртгэлээр хөтөлж, хадгалж хамгаалж сар бүрийн 5-ны дотор үнэт цаасны тайланг нэгтгэж УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст ts.ganchimeg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

1.2. *Байгууллагын хүний нөөцийн талаар:*

2022 онд УБЕГ-аас тус хэлтэст холбогдуулан ирүүлсэн 38 тушаал байгаагаас А тушаал 16, Б тушаал 21, мөн эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч Л.Байгалмаад холбогдуулан УБЕГ-ын Ёс зүйн зөвлөлийн 2022 оны 01 дугаартай тогтоол 1 ирсэн. Үйл ажиллагаа болон албан хаагчтай холбогдуулан гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган, холбогдох арга хэмжээг авч хэлтсийн дарга хяналт тавьж удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.

1.3. *Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд:*

2022.05.13-ны өдөр нийт албан хаагч, сумдын Улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулан улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой анхаарах асуудлын талаарх чиглэл мэдээллийг хүргэж хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголт олгох сургалтыг зохион байгуулж ажиллалаа.



Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр сумдын улсын бүртгэгч нарт 3 удаагийн чиглэл, 16 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр суманд эд хөрөнгийн үйлчилгээ олгож эхэлсэн Хангал, Хишиг-Өндөр сумдын улсын бүртгэгч нарыг дадлага ажлыг гүйцэтгүүлэн нийт 3 удаа цахимаар сургалт мэдээллийг хүргэж өдөр тутмын ажил үйлчилгээнд нь хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.

Тус хэлтэс нь батлагдсан хөтөлбөрийн дагуу албан хаагчдын жендерийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, бодлого төлөвлөлтөд жендерийн дүн шинжилгээ хийж, чадавхийг дээшлүүлэх ажлын хүрээнд 2022.04.15-ны өдөр Булган аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Оюунгэрэлийг урьж “**Жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, түүнээс гарах хор уршиг**” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 32 албан хаагчдыг танхимаар болон цахимаар бүрэн хамруулсан.






ЗДТГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн Дэлгэрмааг урьж нийт албан хаагчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



1.4. *Хяналт шалгалтын чиглэлээр:*

1. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2022 оны хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн 2297 бүртгэл, 2407 лавлагаанд хяналт шалгалт хийж, дотоод албан бичиг үйлдэн Иргэний улсын бүртгэлийн тасагт хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрчитэй бүртгэгдсэн иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу холбогдох бүртгэлийн хянаж

- Засвар өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулах дүгнэлт – 43
- Бүртгэл хүчингүй болгох – 26
- Бүртгэл түдгэлзүүлэх дүгнэлт – 1 нийт 70 дүгнэлт гаргасан байна. 2022 оны хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн 3065 бүртгэл, 2407 лавлагаанд хяналт шалгалт хийж ажиллаа.

2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 31 дүгнэлт, 1 албан шаардлага, 748 бүртгэлд хяналт тавьж ажиллаа.
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1 дүгнэлт гаргаж, 20 бүртгэлд хяналт шалгалтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаа.
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харъяалуулан заасан зөрчлийн талаарх 348 гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс хүлээн авч, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 8.145.0 мян.төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

1.5. *Тоон гарын үсэг олголтын талаар:*

Сумын улсын бүртгэгч нарт 2022.05.13-ны өдөр тоон гарын үсэг болон иргэний улсын бүртгэлийн чиглэлээр анхаарах асуудлуудын талаар сургалт зохион байгуулж ажиллалаа. Сургалтаар лавлагаа олголт, алдаа зөрчлийн талаар, иргэний үнэмлэхийн зураг авах, иргэний улсын бүртгэлтэй холбоотой анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгч сургалтын дараа цахим архивын програмд хайлт хийх, тоон гарын үсгээр E-mongolia-д нэвтрэх, хүний нөөц сургалтын системд нэвтрэх, лавлагаа олгох зэрэг асуудлуудаар багт хуваан дадлага ажил хийлгэж мэдлэгийг бататгаж ажиллалаа.

Тоон гарын үсгийн талаар аймгийн Цагдаагийн газар, Хорих 439-р анги, Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүх шинжилгээний алба, Булган сумын ЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, Боловсролын газар, Татварын хэлтэс, ЭБЦТС “ТӨХК”, Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Булган цаг уур, Булган мэжж зэрэг албан байгууллагад мэдээлэл өгч тоон гарын үсэг олгосон. Аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт **7273** иргэнд тоон гарын үсэг олгоод байна.

1.6. *Иргэний бүртгэлийн чиглэлээр:*

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11.25-ны байлдаар нийт **5116** бүртгэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс:төрөлт 799, үрчлэлт 21, овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 49, эцэг,эх тогтоосны бүртгэл 53, гэрлэлтийн

бүртгэл 176, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 37, нас баралтын бүртгэл 330, шилжилт хөдөлгөөний бүртгэл 1158, иргэний үнэмлэхийн бүртгэл 1855, гадаад паспортын 638 бүртгэл тус тус бүртгэгдсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11 сарын байдлаар нийт 6055 лавлагаа олгосон байна. Үүнд: албан тоотоор-767, албан хэрэгцээнд 1308, иргэнд-3980 лавлагаа олгосон.

Нийт иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн албан бичиг: 2022 оны 11-р сарын байдлаар 79 албан бичгийг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Үүнд: Нөхөн бүртгэл-36 албан бичгээр 126 иргэн
Нэмэлт өөрчлөлт-18 албан бичгээр 165 иргэн
Регистрийн дугаар өөрчлөх 13- албан бичгээр 16 иргэн
Гэрлэлтийн төлөв өөрчлөх-5 албан бичиг 6 иргэн
Нэрийн санд галигын засвар хийх-7 албан бичгээр 13 иргэний мэдээллийг тус тус хүргүүлж шийдвэрлүүлсэн.

1.7. *Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:*

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь 2022 онд ахлах улсын бүртгэгч-1, эд хөрөнгийн улсын бүртгэгч-2, тасгийн хэмжээнд нийт 3 албан хаагчтайгаар жилийн эхний хагаст үйл ажиллагаагаа эрхлэн явуулсан бөгөөд 2022.06.01-ны өдрөөс ахлах улсын бүртгэгч В.Оюун-Эрдэнэ нь өндөр насны тэтгэвэрт гарсан тул үүрэгт ажлаас чөлөөлөгдөж 2022.08.01-ны өдрөөс эхлэн ахлах улсын бүртгэгч томилогдох хүртэл хугацаанд үндсэн албан үүргийнхээ зэрэгцээ ахлах улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэгэгчээр Э.Нандинцэцэгийг томилсноор өнөөдрийн байдлаар 2 бүртгэгчтэйгээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэн ажиллаж байна.

Шинэчлэгдэн батлагдсан эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль журмыг иргэд олон нийтэд сурталчлах, таниулж мэдүүлэх талаар ерөнхий газраас ирүүлсэн удирдамж, чиглэлийн хүрээнд гарын авлага, тараах материалаар иргэдийг ханган, зөвлөгөө мэдээллийг тухай бүрт нь өгч ажиллаж байгаа бөгөөд УБЕГ-аас ирүүлж буй тушаал, шийдвэр, ЭХЭУБГазраас ирүүлж буй чиглэл, зөвлөмжийг өдөр тутмын ажил үйлчилгээндээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд нийт **3560** бүртгэл хийгдсэн. Үүнд:

- Анхны бүртгэл -809
- Өмчлөх эрх шилжих – 743
- Барьцааны гэрээ дуусгавар болгох – 776
- Барьцааны гэрээ – 743
- Бүртгэлд өөрчлөлт оруулах -300
- Лавлагаа, хуулбар –76
- Архивын лавлагаа – 110

Нийт улсын төсөвт үйлчилгээний хураамж- **34.454.219₮** төгрөг.

Татварын орлого-**114.938.540₮** төгрөг.

Улсын тэмдэгтийн хураамж- **1.987.219₮** төгрөг төвлөрүүлэн ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тоон мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл:

| № | Үйлчилгээний төрөл | | Тайлант хугацаа | |
|---|---|---|---|---|
| | | | 2021 он | 2022 он |
| 1 | Өмчлөх эрхийн анхны бүртгэл | | 650 | 809 |
| | үүнээс: | Газар | 302 | 531 |
| | | ГБҮХЭХ | 348 | 246 |
| | | Шинээр баригдсан орон сууц | 32 | 29 |
| 2 | Өмчлөх эрх шилжих гэрээний эрхийн бүртгэл | | 690 | 745 |
| 3 | Барьцааны гэрээ | | 2996 | 1522 |
| | үүнээс: | Барьцааны гэрээ дуусгавар болгох | 1265 | 777 |
| 4 | Бүртгэлд өөрчлөлт оруулах | | 268 | 300 |
| 5 | Лавлагаа, хуулбар | | 140 | 61 |
| 6 | Урьдчилсан тэмдэглэл | | 1 | 2 |
| 7 | Хувийн хэрэг хаах | | 8 | 15 |
| 8 | Нийт бүртгэлийн тоо | | 6703 | 3326 |
| 9 | Архивын лавлагаа | | 160 | 110 |
| 10 | Албан бичиг | | | 72 |
| 11 | Үйлчилгээний нийт хураамж | | 56.392.861₮ | 34.535.219₮ |
| 12 | Тэмдэгтийн хураамжийн нийт дүн | | 1.721.956₮ | 1.987.219₮ |
| 13 | ҮХЭХӨЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого | | 168.242.678₮ | 114.938.540₮ |

1.8. *Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:*

2022 онд нийт **453** бүртгэл хийсэн байна. Мөн E-Mongolia системээр хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах, цахим гэрчилгээ олгох нийт 853 бүртгэл хийсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтанд шинээр нийт 155 аж ахуйн нэгжр, байгууллага үүсгэн байгуулсан бүртгэл хийснээс компани-117, нөхөрлөл-1, төрийн бус байгууллага-17, хоршоо-16, үйлдвэрчний эвлэлийн байгууллага -4 байна. Шинээр үүсгэн байгуулагчтай 115, хоёр буюу түүнээс дээш үүсгэн байгуулагчтай 40 байна.

Шинээр үүсгэн байгуулах өргөдөл, материалыг хүлээн авч хянаж байгаа 5 газар байна.

2022 оны хуулийн этгээдийн хөдөлгөөний болон бүртгэлийн мэдээг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлтийн нэр | | Мөрийн дугаар | Жилийн эхэнд | Тайлант сарын гүйцэтгэл | | Тайлант сарын эцэст багана |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэмэгдсэн | хасагдсан | |
| А | | Б | 1 | 2 | 3 | 4 |
| **Улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээд** | | **01** | **1767** | **155** | **1** | **1921** |
| Хувьцаат компани | | 02 | 4 | - | - | 4 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани | | 03 | 1111 | 117 | 1 | 1227 |
| Үүнээс | Гадаадын хөрөнгө оруулалттай | 04 | 1 | - | - | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Төрийн бус байгууллага | 05 | 124 | 17 | - | 141 |
| Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар | 06 | 3 | - | - | 3 |
| Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар | 07 | 8 | - | - | 8 |
| Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар | 08 | 163 | - | - | 163 |
| Нөхөрлөл | 09 | 156 | 1 | - | 157 |
| Үүнээс: Гадаадын хөрөнгө оруулалттай | 10 | - | - | - | - |
| Хоршоо | 11 | 148 | 16 | - | 164 |
| Хадгаламж, зээлийн хоршоо | 12 | 3 | - | - | 3 |
| Сан | 13 | 5 | - | - | 5 |
| Үйлдвэрчний эвлэлийн байгууллага | 14 | 23 | 4 | - | 27 |
| Шашны байгууллага | 15 | 14 | - | - | 14 |
| Хэвлэл мэдээллийн байгууллага | 16 | 4 | - | - | 4 |
| Боловсрол, сургалтын байгууллага | 17 | - | - | - | - |
| Эрдэм шинжилгээний байгууллага | 18 | - | - | - | - |
| **Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд** | **19** | **200** | **1** | **-** | **201** |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар** | **20** | **-** | **-** | **-** | **-** |
| **Улсын бүртгэлээс хасагдсан гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар** | **21** | **-** | **-** | **-** | **-** |
| **Үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгосон** | **22** | **0** | **42** | **-** | **42** |
| **Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн** | **23** | **0** | **297** | **-** | **297** |
| **Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн** | **24** | **0** | **155** | **-** | **155** |
| **Улсын тэмдэгтийн хураамжийн орлого /Мян.төг/** | **25** | **0** | **17166.0** | **-** | **17166.0** |
| **Тамга, тэмдгийн хяналт, лавлагаа** | **26** | **0** | **262** | **-** | **262** |
| Хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон | 27 | 0 | 212 | - | 212 |
| Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг | 28 | 0 | 50 | - | 50 |
| Хуулийн этгээдэд олгосон тамга, тэмдгийн лавлагаа | 29 | - | - | - | - |
| **Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах** | **30** | **16** | **2** | **-** | **17** |
| Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсан | 31 | 12 | 1 | - | 13 |
| Хуулийн этгээдийн бүртгэлийн хоригийг цуцалсан | 32 | 4 | 1 | - | 5 |

Улсын бүртгэлд бүртгэлтэй ААН, байгууллагын тоо энэ оны эхнээс **155**-аар буюу **8.8%**-иар нэмэгдэж **1921** болсон байна.

Хуулийн этгээдийн нийт **155** нэрийг холбогдох хууль, журмын дагуу баталгаажуулж, Иргэд болон ААН-д **52** лавлагаа, мөн Статистикийн хэлтэс, ХХААЖДҮГ, Хоршоологчдын холбоо, Аудитын газар, Татварын хэлтэс, АЗДТГ, сум дундын болон аймгийн шүүх, ШШГА, аймгийн Тагнуулын газарт шаардлагатай мэдээлэл лавлагааг тухай бүрт нь үнэн зөв, шуурхай гаргаж ажиллалаа. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг, улсын бүртгэлийн жагсаалтад өөрчлөлт оруулах болон өөрчлөн байгуулагдах замаар байгуулагдсан хуулийн этгээдийн 297 өргөдөл хүлээн авч шийдвэрлэлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээгээ гээсэн болон гэмтээсэн, улсын бүртгэлийн дугаар буюу харьяалал өөрчлөгдсөн

шалтгаанаар нийт **42** гэрчилгээ дахин олгосон. Шилжилт хөдөлгөөний тухайд, нийслэлээс шилжин ирсэн 2, Өвөрхангай аймгаас шилжэн ирсэн 1, нийслэл рүү шилжсэн 1, Орхон аймаг руу шилжсэн 1, нийт 5 материал байна. Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл хуулийн хугацааны хувьд 1 хийгдсэн байна. Оны эцэст энэ бүртгэлийн тоо 31-ээр нэмэгдэнэ.

Монгол Улсын Хууль зүйн сайдын 2018 оны тушаалаар батлагдсан " Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам"-ыг баримтлан **212** хуулийн этгээдэд хяналтын дугаар олгож, **50** тамга хураан авсан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээнээс улсын болон орон нутгийн төсөвт **17,166,000** төгрөгийн орлого оруулсан. Улсын тэмдэгтийн хураамжийг үйлчилгээний төрлөөр нь задалж хүснэгтээр харуулбал:

| Д/д | Тэмдэгтийн хураамжийн орлогын нэр | Бүртгэлийн тоо | Дүн /төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 |
| 1 | Хуулийн этгээдийг шинээр улсын бүртгэлд бүртгэхэд | 155 | 6,820,000 |
| 2 | Үүсгэн байгуулах баримт бичиг болон улсын бүртгэлийн жагсаалтанд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн | 297 | 2,970,000 |
| 3 | Улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон | 42 | 3,696,000 |
| 4 | Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхэд | 0 | 0 |
| 5 | Татан буугдсан бүртгэл | 1 | 10,000 |
| 6 | Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийхэд | 155 | 1,550,000 |
| 7 | Тамга тэмдгийн хяналтын дугаар өгөхөд | 212 | 2,120,000 |
| БҮГД | | | 17,166,000 |

Мөн E-Mongolia системээр хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах, цахим гэрчилгээ олгох нийт 853 бүртгэл хийсэн.

1.9. *Санхүүгийн чиглэлээр:*

Тус хэлтэс нь 2022 онд үйл ажиллагааны зардалд 460,266.8 сая төгрөгийн батлагдсан төсөвтэйгөөр чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагааны хүрээнд бий болсон 104,294.5 мянган төгрөгийн орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2022 оны 11 сарын тайлангийн хугацаанд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 17,620.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 13,462.9 мянган төгрөг, багаж техник хэрэгсэлд 1,252.5 мянган төгрөг, нийт 14,715.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Мөн холбогдох хууль тогтоол шийдвэрийн дагуу ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 96 нэр төрлийн 30,754.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил актлахаар УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.

Төрийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 1-ээс 08 дугаар сарын 15-ны өдрийг дуустал явагдсан ажлын хэсэг гарч тооллогыг маш сайн хийж гүйцэтгэж цахимаар илгээж цаасаар орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн өдөр бүр, сар бүрийн эцэст гаргадаг тайлан мэдээг хугацаанд нь хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Сар бүрийн харилцахын баримтын бүрдэлтийг шалгаж, цэгцэлж байна.
- Санхүүжилт орсон үед цалин болон бусад гүйлгээг хийж байна.
- Нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 5-ны дотор гаргаж, нийгмийн даатгалаар баталгаажуулан 11 дүгээр сарын 01-ээс тоо гарын үсгээр илгээж байна.
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 1-ны дотор гаргаж, ил тод мэдээллийн самбарт байршуулсан.
- Шилэн дансны мэдээг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны сайтад хугацаа хоцроолгүй байршуулж байна.
- Улирал бүр татварын тайлан хийж татварын хэлтэсээр баталгаажуулж байна.

1.10. *Архивын үйл ажиллагааны чиглэлээр:*

2022 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтсийн иргэний бүртгэлийн архивт 81766,ЭХЭБ-ийн 20299,хуулийн этгээдийн 1776 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Иргэний баримт бичгийн архивт иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 8 тєрєл иргэний үнэмлэх олголтын ИУБ-21, иргэний шинэчилсэн бүртгэлийн маягт-31,ИҮДАӨ,шилжилт хөдөлгөөний ИУБ-22 төрлүүдээр нийт 9729 иргэдийн хувийн хэргийг жилийн эцсийн байдлаар хүлээн авч архивт байршууллаа. Төрөл тус бүрээр нь авч үзвэл ИУБ-11 маягт 696, ИУБ-12 маягт 18-г, ИУБ-13 маягт 41-г, ИУБ-14 маягт 41, ИУБ-15 маягт 155-г, ИУБ-16 маягт 28 г, ИУБ-18 маягт 289-г , ИУБ-22 маягт – 1737,ИУБ-31 маягт-1913-г,ИУБ-21 маягт-1644 ИҮДАӨ-196-г жагсаалтаар хүлээн авч архивт байршуулан ажиллаа.

ИБТасгийн архивын хувийн хэргийн тооллогын ажлыг хэлтсийн даргын тушаалаар комисс томилогдон бүрэн дуусгаж,архивт байршиж буй иргэдийн хувийн хэргүүдийг эхсел программ дээр нэг бүрчлэн шивж пайл үүсгэн мэдээллийн санд шалган бусад аймгийн хаягтай 6856, иргэний хувийн хэргийг ялган жагсаалт үйлдэж хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаа.Нийт 46444 хувийн хэрэг тоологдсоноос 6856 иргэний хувийн хэрэг өөр аймгийн хаягтай,198 нас барсан,82 тодорхойгүй төлөвтэй хувийн хэргийг ялган 39308 хувийн хэргийг архивт галигын дагуу байршуулан ажиллаа.

Мөн шинээр 16 нас хүрч иргэний цахим үнэмлэх захиалсан 635 иргэний ИУБ-31 маягтыг ИУБ-11 маягттай хавсарган шинээр архивын хувийн хэрэг үүсгэн цагаан толгойн галигын дагуу архивт байршууллаа

ЭХЭУБ-ийн архивт нийт 20299 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газраас бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 8396,газрын бүртгэл 10007,эзэмших газар 1887, ашиглах газар 9 –г сум тус бүрээр газар,үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээр ангилан архивт байршуулсан байгаа болно.

Энэ оны байдлаар ЭХЭБТ-ийн архивт шинээр газраас бусад эд хөрөнгийн хувийн хэрэг 274, газрын хувийн хэрэг 528-г шинээр нээж архивт өгсөнг журналаар хүлээн авч сум тус бүрээр шинээр хувийн хэрэг үүсгэн дугаарын дагуу байршуулж ажиллаа.

Тус тасгийн архивын хувийн хэрэг багтахгүй болсоноос шинээр нягтруулсан шүүгээ авах шаардлагатай байгаа учраас өөрсдийн нөөц бололцоогоор 2 нягтруулсан шүүгээний тавцанг 2 тавцангаар дээш сунган архивын багтахгүй байгаа хувийн хэргүүдийг байршуулан ажиллаж байна.




/зураг/

Мөн ЭХЭУБ-ын хувийн хэргүүдээс хадгалах хугацаа дууссан болон устгах шаардлагтай байгаа материалуудын жагсаалтыг гарган УБЕГ-т шийдвэрлүүлэхээр хүргүүлж ажилласан. Тус тасгийн архивт 1922 хувийн хэрэг байршиж байгаагаас шинээр 155, татан буугдсан 1 бүртгэл хийгдсэн байна. Аймгийн сум дундын шүүхээс тус архивын “Зулзаган түшиг”,”Шинэ амжилт” гэх 2 компаний хувийн хэрэгт 3 удаагийн үзлэг хийгдсэнг шаардлагатай материалыг канондах болон протокол үйлдэн буцаан архивт байршуулж ажиллаа.

Архивын байрны галын буланг сэргээн “Гамшиг ослын үед архивын байрнаас баримт материалыг зөөвөрлөх хуваарийг хэлтсийн даргын тушаалаар томилуулан, хэлтсийн байранд гамшиг осол гарсан үед хийх дадлага сургуулийг нэг удаа зохион байгуулан ажилласан.





1.11. *Мэдээлэл технологийн чиглэлээр:*

- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий газраас Мэдээлэл технологи, Иргэний ахлах улсын бүртгэгч, Хэлтсийн даргад тоон гарын үсгийн сургагч багш бэлдэх сургалтанд 2022 оны 04 дүгээр сарын 13-14 өдрүүдэд хамрагдсан.




- ✓ Тоон гарын үсэг иргэний үнэмлэхэд олгохтой холбогдуулан хүлээн авсан Gimalto, Хурууны хээ уншигч төхөөрөмжүүдийг хэлтэс болон 16 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн.
- ✓ Хэлтсийн www.bulgan.burtgel.gov.mn вэбсайтыг тогтмол хөтөлж, байгууллагын онцлох үйл ажиллагаа мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. Вэбсайт дээр нийт 68 мэдээлэл оруулсанаас 10-н видео мэдээ орсон байна.
- ✓ Сүлжээний гэмтлийг, төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг засварлах ажлаар нийт 5-н сумдын компьютерын хэвийн ажиллагааг ханган ажилласан. Үүнд:

  2022.01.27-нд Хутаг-Өндөр сумын Media converter нэг тал нь шатсан байсныг сольсон.

  2022.02.22-нд Хишиг-Өндөр сумын сүлжээний ROUTER-ийн PORT ажилахгүй байсанг УБЕГ-тай ярижж тохиргоог шинээр хийлгэсэн.

  2022.04.11-нд Тэшиг сумын сүлжээний UTP кабель тасарсаныг сольсон.

  2022.06.10-нд р сард Сайхан сумын сүлжээний JAMPER кабель гэмтсэнийг сольсон.

  2022.08.05-нд Бүрэгхангай сумын сүлжээний ROUTER гэмтсэнийг шинэчлэн сольсон
- ✓ Тогны хэлбэлзлээс болж шатсан Хутаг-Өндөр, Бүрэгхангай, Хялганат тосгон, Сэлэнгэ, Бугат сумдын компьютерийн тэжээлийн блок, принтерийн конденсатор болон гал хамгаалагч эвдэрч гэмтсэнг янзлуулсан.
- ✓ Байгууллагын ажилтнуудын компьютер, түүний дагалдах хэрэгслүүдэд гарч байгаа програмын болон тоног төхөөрөмжийн гэмтлийг засварлаж нийт 50 гаран засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

## ХОЁР. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Булган сумын ЗДТГ-с 2022.03.23-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцож иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч гарын авлага, материал тарааж мөн иргэний үнэмлэх, гадаад паспорт, эд хөрөнгийн гэрчилгээ олголтын үйлчилгээг үзүүлж ажилласан. Мөн И-Монголиа сайтыг сурталчилж 16 иргэнд лавлагаа олголтын чиглэлээр зөвлөгөө өгч ажиллалаа.







2.2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд "Иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийх" ажлын хүрээнд БУЛГАН АЙМГИЙН ЗДТГ-ын "ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС"-ийн мэргэжилтэн, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч С.Амар, БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР нь "Хяналт" хэсэгчилсэн арга хэмжээ ажлыг зохион байгуулан ажилласан.



2.3. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний Киоск /цахим машин/ машиныг хэлтэст авах саналыг аймгийн Удирдлагад хүргүүлж аймгийн 2023 оны төсөвт тусгуулсан амжилттай байна.

## ГУРАВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР:

3.1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжыг заавал банкинд очиж тушааж баримтаа авч ирсний дараа үйлчилгээг хүлээн авдаг байсан явдлыг шийдвэрлэж улсын бүртгэгч Э.Нандинцэцэгийн санаачилгаар төрийн банктай хамтран ЭУБ-ийн тасагт пос машиныг байршуулан 2022.07.25-ны өдрөөс эхлэн үйлчилгээний хураамжийг карт уншуулан тушаалгаж эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжоор бүрэн ханган ажиллаж байна.



3.2. Булган сумын Төрийн захиргааны албан хаагчдын дунд зохиогдсон гар бөмбөгийн тэмцээнд 3-р байр ХҮРЭЛ медаль хүртэж мөнгөн шагналаар шагнагдсан.



3.3. Булган аймгийн ЗДТГ-Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан БАТАК тэмцээнд мэдлэг оюунаа сорин амжилттай оролцож ТУСГАЙ байрын шагнал хүртсэн



3.4. Тус хэлтэс нь Монгол бичгийн сургалтыг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан, дадлага олгох ажлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Раднаабаяр хэлтсийн албан хаагчдад Үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах хичээлийг тогтмол 7 хоногийн Мягмар гаригт 2 цагийн хичээлийг зохион байгуулж ажиллаж байна.





Тайлан нэгтгэсэн:

Улсын бүртгэгч Э.Нандинцэцэг

2022.12.02